

## ХӨВСГӨЛ АЙМГИЙН БООМЫН ГОЛОМТЫН МЭДЭЭЛЭЛ

**Н. Норов<sup>1\*</sup>, Б. Лхам<sup>2</sup>, Ц. Батболд<sup>2</sup>, О. Хурцбаатар<sup>2</sup>, З. Түвшинзаяа<sup>2</sup>,  
Н. Энхцэцэг<sup>2</sup>, Ж. Энхтуяа<sup>2</sup>**

1-Хөдөө Аж Ахуйн Их Сургууль  
2-Мал эмнэлгийн хүрээлэн

Email: \*nnatsag@gmail.com

Монгол улсад сүүлийн жилүүдэд боом өвчний гаралт, тархалт эрс нэмэгдэн, байгалийн голомтууд сэргэн идэвхжиж хүн, малын боомын тохиолдол улам нэмэгдсээр байна. Сүүлийн 20 гаруй жилд гэхэд л 18 аймгийн 94 суманд 1294 малын боом, 16 аймгийн 56 суманд 143 хүний боомын тохиолдол тус тус бүртгэгдсэн байна. 2010 оноос “Боом өвчинтэй тэмцэх сэргийлэх стратеги боловсруулах”-ын тулд хүн, малын боомын өвчлөлийн мэдээлэлийн сан бүрдүүлэх, боомын голомтын зураглал гаргах, боомын дэгдэлт болон голомтын идэвхжлийг байгалийн хүчин зүйл (цаг уурын мэдээ, уур амьсгалын өөрчлөлт, хөрсний бүтэц, байгалийн эсрэгбием) болон хүний хүчин зүйл (малын шилжилт хөдөлгөөн, уул уурхайн олборлолт, вакцинжуулалтын чанар, малчдын мэдлэг, зан үйл)-тэй харьцуулан тодорхойлох зэрэг ажлуудыг хийж байна. Боом өвчинтэй тэмцэх сэргийлэх ажлын хамгийн гол үндэс суурь нь боомын голомтыг газар зүйн байршлаар нарийвчлан гаргаж идэвхжлийг тогтоох явдал юм. Бид Монгол орны боомын голомтын зураглалыг GIS газар зүйн мэдээллийн санд суурилан аймаг тус бүрээр гаргах ажлыг 2010 оноос эхлүүлсэн бөгөөд Хэнтий аймгийн боомын голомтын зураглалыг бүрэн гаргаж Хөвсгөл аймгийн боомын голомтын зураглалыг гаргах ажлыг эхлүүлэн анхан шатны үр дүнг мэдээлж байна. Хөвсгөл аймаг нь 2015 оны жилийн эцсийн байдлаар 4,398,064 толгой мал тоолуулснаас 195,671 адуу, 392,028 үхэр, 2,123,735 хонь, 1,684,635 ямаа, 1,995 тэмээтэй [3]. Мал эмнэлгийн

мэдээгээр 1996-2016 онд Монгол улсын 19 аймгийн 164 сумын нутагт малын боом өвчин бүртгэгдсэн байгаагаас Хөвсгөл аймагт дийлэнх нь байна [2]. Хөвсгөл аймаг нь газар зүйн байршлын хувьд боом өвчний байнгын идэвхитэй голомт бүхий өндөр эрсдэлтэй бүсэд оршдог [1]. Бид боом өвчний гаралт өндөр Хөвсгөл аймгийг сонгон авч 1964-2016 оны малын боом өвчний мэдээг аймгийн Мал эмнэлгийн хэлтсийн мэдээ, архивыг түүвэрлэн цуглуулан авав. Хөвсгөл аймгийн 1964-2015 оны малын боом өвчний мэдээллийн анхан шатны боловсруулалтыг MS-Excel програм дээр, статистикийн боловсруулалтыг Epi Info7.0 програм дээр, газар зүйн мэдээллийн сангаас суурь зураг авч голомтын байршилыг буулган ArcGIS 10.1 програм дээр зураглал хийлээ. Хөвсгөл аймгийн малын боом өвчний 1964-2015 онуудад тэмдэглэсэн дүн мэдээг нэгтгэн статистик боловсруулалт хийж үзэхэд нийт 51 жилийн 39 жилд нь боом өвчин бүртгэгдсэн бөгөөд 1983 оноос 2015 он хүртэл тасралтгүй гарсан байна. 1964 оноос хойш нийт 425 голомт бүртгэгдэж 1580 мал өвчилснөөс үхэр 1,182 буюу 75%, хонь 162 буюу 10%, адуу 157 буюу 9,9%, ямаа 62 буюу 4%, малын төрөл нь тодорхойгүй 17 буюу 1,1% эзэлжээ. Үүнээс 2000, 2015 онуудад хамгийн их дэгдэлт бүртгэгдсэн бөгөөд 2000 онд 23 голомтонд 175 үхэр, 19 хонь үхсэн байсан бол 2015 онд 31 голомтонд 151 адуу, 15 үхэр, 7 ямаа үхсэн байна. Малын боом өвчний 425 голомтын 98 буюу 23% нь GPS-ийн цэгийн бүртгэлтэй байгааг ашиглан анхан шатны зураглал гаргав.

Хөвсгөл аймгийн 1964 оноос хойших малын боом өвчний мэдээллийг цэгцэлж бүрэн болгоход илүү анхаарч голомтын байршлыг баталгаажуулах, тодорхой болгох нь зүйтэй. Цаашид хүчин зүйлийн хамаарлыг өргөн хүрээнд авч үзэн

тооцох шаардлагатай байна. Мөн орон нутгийн мал эмнэлгийн нэгжид GPS төхөөрөмж болон түүнийг зөв ашиглах хангалтгүй байгаа нь голомтын тэмдэглэгээг бүрэн хийх боломж тааруу байгааг харуулж байна.



1-р зураг. Хөвсгөл аймгийн малын боом өвчний голомтын анхан шатны зураглал

## НОМ ЗҮЙ

1. Батсуурь. Н “Монгол дахь бактерит зарим зооноз өвчний тархалт, эрсдэлийн түвшингийн судалгаа” Мал эмнэлгийн ухааны докторын зэрэг горилсон бүтээл. Улаанбаатар хот 2003 он
2. Дэлхийн банкны “Шинэ болон дахин сэргэж буй халдварт өвчинтэй тэмцэх чадавхийг бэхжүүлэх төсөл” -ийн Боом өвчний голомтын судалгаа төслийн тайлан Улаанбаатар хот 2014 он
3. Статистикийн мэдээллийн нэгдсэн сан / [www.1212.mn](http://www.1212.mn) /
4. Хөвсгөл аймгийн боом өвчний 1964-2015 оны архив.